



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 19 өдөр

Дугаар А/687

Мөрөн сум

Уриалга гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.2, 16.1.8 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Монгол үндэсний өв уламжлалаа дээдлэн хүндэтгэх, ардын зан заншил, өв соёлоороо бахархах, үндэсний хувцасны язгуур хэв шинж, угсаатны дээл хувцас, эд хэрэглэл, соёлын биет бус өвийг сурталчлах, орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжих зорилгоор сар бүрийн эхний 7 хоногийн даваа гарагийг “Үндэсний хувцасны өдөр” болгож, Монгол хувцсаа өмсөж хэвшихийг сумдын удирдлагууд, агентлаг байгууллагын дарга нар болон төрийн албан хаагчид, аж ахуй нэгж байгууллага, нийт иргэдэд уриалсугай.

2.Захирамжийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг танилцуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтэс (Цэцэгмаа)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ТӨМӨРБААТАР